



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 36 (609)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Цэрэндэжидийн Бямбажавт дэслэгч генерал цол хүртээх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын хүн амын насжилтын асуудлаархи Үндэсний стратегийн тухай*

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- *Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвтэл

2009 оны есдүгээр сарын 25 № 36 (698)

Улаанбаатар хот

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

484.	Пак Дай Воныг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 63	787
485.	Баянмөнхийн Билэгтийг албан тушаалд томилох тухай	Дугаар 64	787
486.	Далхжавын Сандагийг албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 65	788
487.	Цэрэндэжидийн Бямбажавт дэслэгч генерал цол хүртээх тухай	Дугаар 66	788
488.	Бямбасүрэнгийн Баярмагнайд бригадын генерал цол хүртээх тухай	Дугаар 67	788
489.	Фейсал Рашедь Аль-Гайсыг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 69	788
490.	Анатолий Алексеевич Голубевыг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 70	788

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

491.	Эрх олгох тухай	Дугаар 154	789
492.	Монгол Улсын хүн амын насжилтын асуудлаархи Үндэсний стратегийн тухай	Дугаар 156	789
493.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 157	789
494.	Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай	Дугаар 158	795
495.	Үл хөдлөх хөрөнгө худалдах, балансаас балансад шилжүүлэх тухай	Дугаар 161	796

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

496.	Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 21	798
------	---	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

ПАК ДАЙ-ВОН-ЫГ "НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Монгол Улс, БНСУ хоорондын найрсаг хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн цахим Монгол засаглал, бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болгох, мэдээлэл, харилцаа, холбоо, технологи, экологи, хүнсний эрүүл мэнд, дэд бүтцийн салбарт үзүүлсэн оюуны болон материаллаг тусламж, өндөр ач холбогдол

бүхий төслүүдийг хэрэгжүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмрийг нь үнэлж БНСУ-ын "Олон улсын хамтын ажиллагааны агентлаг"-ийн Ерөнхийлөгч ноён Пак Дай-Вон-ыг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

БАЯНМӨНХИЙН БИЛЭГТИЙГ АЛБАН ТУШААЛД ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Баянмөнхийн Билэгтийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тусгай албад хариуцсан шинжээчээр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

ДАЛХЖАВЫН САНДАГИЙГ АЛБАН ТУШААЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хариуцсан шинжээчийн албан тушаалаас хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн чөлөөлсүгэй.

ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Далхжавын Сандагийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тусгай албад

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

ЦЭРЭНДЭЖИДИЙН БЯМБАЖАВТ ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ ЦОЛ ХҮРТЭЭХ ТУХАЙ

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан цол хүртээсүгэй.

ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

БЯМБАСҮРЭНГИЙН БАЯРМАГНАЙД БРИГАДЫН ГЕНЕРАЛ ЦОЛ ХҮРТЭЭХ ТУХАЙ

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан бригадын генерал цол хүртээсүгэй.

ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Зэвсэгт хүчний Жанжин штабын дэд дарга-

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

ФЕЙСАЛ РАШЕД АЛЬ-ГАЙС-ЫГ "НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Монгол Улс, Кувейт Улсын хоорондын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, хамтын ажллагааны үндсийг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Кувейт Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Фейсал Рашед Аль-Гайс-ыг "Найрамдал" медалиар шагнасугай.

Монгол Улс, Кувейт Улсын хоорондын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, хамтын ажллагааны үндсийг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Кувейт Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Фейсал

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

АНАТОЛИЙ АЛЕКСЕЕВИЧ ГОЛУБЕВ-ЫГ "НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайдын яамны өмч хөрөнгийг хадгалж, хамгаалахад олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа ОХУ-ын иргэн Анатолий Алексеевич Голубев-ыг "Найрамдал" медалиар шагнасугай.

Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайдын яамны өмч хөрөнгийг хадгалж, хамгаалахад олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа ОХУ-ын иргэн Анатолий Алексеевич Голубев-ыг "Найрамдал"

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

Эрх олгох тухай

Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 10.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын тохируулагч агентлаг-Цөмийн энергийн газрын дарга Содномын Энхбатад цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий

байцаагчийн эрх олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Б.ДОЛГОР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 156

Улаанбаатар хот

Монгол Улсын хүн амын насжилтын асуудлаархи Үндэсний стратегийн тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.7-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хүн амын насжилтын асуудлаархи Үндэсний стратегийг сайшаасугай.

2. Үндэсний стратегийг баталж, зорилтуудыг нь салбарын болон үндэсний хөгжлийн дунд, урт хугацааны бодлогын баримт бичиг, холбогдох хууль тогтоомжийн төсөлд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн

хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун)-нд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

Т.ГАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, "Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг хандивлагч орнуудын зээл тусламжид хамруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, жил бүрийн улсын төсөвт тусгах замаар санхүүжүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд

С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Е.Отгонбаяр, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг жил бүрийн III улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х. Баттулгад үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Х.БАТТУЛГА



Засгийн газрын 2009 оны 157 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол орны нутаг дэвсгэрт өнгөрсөн зуунд олон тооны газар хөдлөлт болж байснаас 1905 оны Булхайн болон Цэцэрлэгийн (8,3 магнитуд), 1931 оны Монгол Алтайн (8 магнитуд), 1957 оны Их богдын (8,3 магнитуд) 1967 оны Могодын (7,3 магнитуд) гэх хүчтэй газар хөдлөлтүүд болж тэдгээр нь хот, газар газраас алс хол, хүн ам сийрэг газарт болсон тул хохирол багатай байжээ.

Газар чичирхийллийг хэмжих анхны станцыг БНМАУ (хуучин нэрээр)-ын Сайд нарын Зөвлөлийн 1956 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 565 дугаар тогтоолын дагуу 1957 онд байгуулсан байна.

Монголын газар хөдлөлтийн 1:2500000 масштабтай ерөнхий мужлалын зургийг 1982 онд боловсруулж 1988 оноос одоог хүртэл хот байгуулалт, барилгын зураг төсөл зохиох ажилд ашиглаж байна. Улаанбаатар хотын бичил мужлалын ерөнхий схем зургийг 1968 онд хийсэн бөгөөд өнөөдрийг хүртэл барилгын зураг төслийн ажилд ашиглаж байна.

Манай орны суурин газрын 75 орчим хувь нь газар хөдлөлтийн 7 болон түүнээс дээш, 12 суурин газар нь газар хөдлөлтийн 9 болон түүнээс дээш баллын бүс нутагт оршиж байна. Газар хөдлөлтийн 7 болон түүнээс дээш баллын бүс нутагт манай нийт хүн амын 86 хувь амьдарч байна. 2007 онд Улаанбаатар хотын хэмжээнд явуулсан орон сууцны барилгын тооллогын дүнгээс харахад нийт барилгын 4,6 хувь нь газар хөдлөлтийн нөлөөллийг тооцоогүй зураг төслөөр баригдсан байна.

Сүүлийн жилүүдэд манайд хүн амын төвлөрөл эрчимтэй явагдаж өнөөдрийн байдлаар нийт хүн амын 60,2 хувь нь хот, суурин газарт амьдарч байгаа тул болзошгүй газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг багасгах асуудалд анхаарах шаардлагатай байна.

Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлаар болзошгүй шууд болон шууд бус хор нөөцлийн үнэлгээ хийх, түүнийг урьдчилан таамаглах, улсын болон тухайн бүс нутгийн хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг салбар дундын түвшинд иж бүрнээр нь шийдвэрлэхийг өнөөгийн нөхцөл байдлаар зайлшгүй шаардаж байна.

Хоёр. Зорилго

Хөтөлбөрийн зорилго нь Монгол орны нутаг дэвсгэрт учирч болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хүчтэй газар хөдлөлтийн голомт бүхий бүс нутагт гамшгийн эрсдэлийг бууруулах, ашиглагдаж байгаа зарим барилга, байгууламжийн хийц, бүтээцийг хүчитгэх замаар эвдрэл, нуралтаас үзэх хохирлыг багасгах, орон сууц, олон нийт, иргэн болон үйлдвэрийн барилга, зам гүүр, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж, инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлыг хангах, байгалийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна:

3.1.1. газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, судалгаа, сургалт, авран хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх;

3.1.2. газар хөдлөлтийн аюулын үнэлгээ хийж, ерөнхий болон бичил мужлалын зураг зохиох, газар хөдлөлт бүртгэх станцын сүлжээг өргөтгөх;

3.1.3. хот суурин болон бүс нутгийн эрсдэлийн үнэлгээг хийж;

3.1.4. гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Хөтөлбөрийн 3.1.1 дэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.1.1. газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, судалгаа, сургалт, авран хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд, эрдэмтэн судлаач, инженер техникийн болон бусад төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, олон улсын ижил чиг үүрэг бүхий зөвлөл, байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, хамтын ажиллагааг тогтворжуулах, олон улсын мэргэжлийн байгууллага, нийгэмлэгт элсэх, хамтарсан сургалт, семинар зохион байгуулахад туслалцаа үзүүлэх;

4.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт болсон газар хөдлөлтийн бүртгэлийн мэдээллийн санг баяжуулах, олон улсын мэргэжлийн байгууллага, нийгэмлэгтэй мэдээлэл болон мэргэжилтэн харилцан солилцох, үндэсний мэргэжилтэн бэлтгэх, дадлагажуулах ажлыг зохион байгуулах;

4.1.3. олон нийтэд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх болон газар хөдлөлтийн гамшгийн үеийн авран хамгаалах сургалт зохион байгуулах, сурталчлах, гамшгийн хор холбогдлыг тайлбарлан таниулах;

4.1.4. гамшгийн хор холбогдлыг бууруулахад шинжлэх ухаан, технологийн олголт, амжилтыг нэвтрүүлэх;

4.1.5. хот байгуулалт, барилгын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрт газар чичирхийллийн нөлөөллийг тооцох, төлөвлөх хичээл нэмэх, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, кредит цагийг нэмэгдүүлэх, багш нарыг давтан сургах, мэргэшүүлэх;

4.1.6. газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн хүмүүст эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх сургалт зохион байгуулах.

4.2. Хөтөлбөрийн 3.1.2 дахь зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.2.1. Монгол орныг хамарсан газар хөдлөлтийн ерөнхий мужлалын зураг боловсруулах ажлыг нэгдсэн аргачлал, шинжлэх ухаан, технологийн дэвшилд тулгуурлан зохион байгуулах;

4.2.2. газар хөдлөлтийн өндөр эрсдэл бүхий хот, суурин газар, бүсүүдийн тулгуур төв болон зарим суурин газрын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:10000-ны масштабтай газар хөдлөлтийн бичил мужлалын зураг зохиох ажлыг үе шатаар хэрэгжүүлэх;

4.2.3. хүн ам олноор суурьшсан Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хөрсний хурдатгалын бичлэг /акселограмм/ хийх;

4.2.4. орон нутагт ажиллаж байгаа газар хөдлөлт бүртгэх станцын дэд бүтцийг сайжруулах боловсон хүчний чадавхийг нь дээшлүүлэх;

4.2.5. газар хөдлөлтийн судалгаа эрхэлдэг байгууллагыг газар хөдлөлт бүртгэх нүүдлийн станц болон геофизикийн орчин үеийн иж бүрэн багаж, техник хэрэгслээр хангах;

4.2.6. газар чирхийллийг бүртгэх, мэдээлэл боловсруулах байнгын станцыг шинээр байгуулах.

4.3. Хөтөлбөрийн 3.1.3 дахь зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.3.1. газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, тектоникийн судалгааны ажлыг орчин үеийн технологийн түвшинд хийх;

4.3.2. хангайн, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийх;

4.3.3. эрдэс баялаг, уул уурхайн томоохон цогцолборуудыг дагаж байгуулагдах суурин газрын газар хөдлөлтийн эрсдэлийг тогтоосон баримт бичиг боловсруулах;

4.3.4. хот, суурин газруудын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний ажлыг дуусгаж, мэдээллийн сан байгуулах;

4.3.5. хангайн, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотод ашиглагдаж байгаа 1970 оноос өмнө баригдсан олон нийт, иргэний болон үйлдвэрийн барилга, дэд бүтцийн байгууламжуудад үзлэг, тооллого явуулж, паспортжуулах, газар хөдлөлтийн төсвэрлэлтийн нэмэлт арга хэмжээг үе шатаар эхлүүлэх;

4.3.6. барилга байгууламжийг загварчилж бодит байдалд турших, дүн шинжилгээ хийх, барилгын бүтээц болон түүний элементийг газар хөдлөлтөд турших, багаж, тоног төхөөрөмж бүхий лабораторитой болгох, ашиглагдаж байгаа туршилтын багаж, тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх;

4.3.7. хот, суурин газрыг төлөвлөх, барилгажуулах төсөлд газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл тодорхойлох талаар явуулсан сүүлийн үеийн судалгааны ажлын үр дүнг тусгах;

4.3.8. хангайн, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотын

1:1000-аас доошгүй масштабтай газрын дижитал зургийн санг байгуулах;

4.3.9. эрүүл мэнд болон боловсролын байгууллагын барилгын даац, бат бэх, газар хөдлөлтөд тэсвэртэй байдлын үнэлгээ хийх.

4.4. хөтөлбөрийн 3.1.4 дэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.4.1. газар хөдлөлтийн гамшгийн төлөвлөгөөг томоохон хот суурин газар бүрээр боловсруулж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх;

4.4.2. гамшгаас хамгаалах алба, аймаг орон нутагт явуулдаг газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх дадлага, сургалтад холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллаж, болзошгүй гамшгийн үед ажиллах хамтын ажиллагааг сайжруулж, газар хөдлөлтийн гамшигтай тэмцэх чадавхийг дээшлүүлэх;

4.4.3. газар хөдлөлтийн гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөөг томоохон хот суурин газар бүрээр хэрэгслийг буцалтгүй тусламж, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хамруулан шинэчлэх арга хэмжээ авах.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана:

5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2. гадаадын зээл, тусламж;

5.1.3. бусад эх үүсвэр.

5.2. Улсын төсөвт тусган санхүүжүүлэх хөрөнгийг тухайн асуудлыг хариуцсан сайдын төсвийн багцад жил бүр тусгана.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт, хяналт

6.1. Хөтөлбөрийг 2009-2014, 2015-2020 гэсэн хоёр үе шатаар хэрэгжүүлнэ.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрхэлсэн асуудлаараа төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, харьяа нутаг дэвсгэртээ аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцна.

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах үйл ажиллагааг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн

7.1. Хөтөлбөр хэрэгжсэнээр болзошгүй газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хамтран ажиллаж, газар хөдлөлтийн эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үнэлэх нөхцөл бүрдэнэ.

7.2. Монгол орны газар хөдлөлтийн эрсдэл өндөр хот, суурин газрын дэд бүтцийн инженерийн шугам сүлжээнд газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.



7.3. 1970 оноос өмнө төв, суурин газарт баригдсан олон нийт, иргэний болон үйлдвэрийн барилга, байгууламжийн газар хөдөлтийг тэсвэрлэх чадвар нормативт хэмжээнд хүрсэн байна.

7.4. Газар хөдөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах механизм бүрдэж, газар хөдөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн ажиллагаа салбарын яамд, эрдэм шинжилгээний байгууллага, иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжих орчин шинээр бий болно.

7.5. Улсын хэмжээний бүртгэл, мэдээллийн тогтолцооны дэд сан болох газар хөдөлтийн гамшгийн эрсдэлийн мэдээллийн сан байгуулагдана.

7.6. Барилга байгууламжийг газар хөдөлтийн эрсдэлтэйгээр төлөвлөх, барих, ашиглах ажлыг гардан гүйцэтгэдэг үндэсний мэргэжилтнүүд бэлтгэгдэж, шинжлэх ухаан, технологийн инноваци эрчимтэй нэвтэрснээр газар

хөдөлтийн гамшгийн эрсдэлийг багасгах орчин бүрдэнэ.

7.7. Барилга байгууламжийн хийц, элементийн бат бэх, тогтворыг турших лабораторитой болсноор барилга байгууламжийн тогтвор, чанарыг нэмэгдүүлж, хүн амын аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрдэнэ.

7.8. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнд монгол орныг хамарсан газар хөдөлтийн ерөнхий мужлалын зураг шинэчлэгдэж, нийслэл, зарим төв, суурин газрын бичил мужлалын зургийг зохионо.

7.9. Дэд бүтцийн салбарын боловсон хүчний мэдлэг, дадлага, туршлагыг дээшлүүлснээр барилга байгууламжийн бат бэх чанар дээшилж, үр ашигтай техникийн шийдэл, материал, технологи нэвтрэн, эвдрэл сүйрэл багасна.

7.10. Эрүүл мэнд болон боловсролын байгууллагуудын барилга байгууламжийн чанар, аюулгүй байдал сайжирна.

Засгийн газрын 2009 оны 157 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"ГАЗАР ХӨДӨЛТӨЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүнд	Үр дүнгийн шалгуур	Хугацаа	Хариуцах байгууллага
Нэг, Газар хөдөлтөөс урьдчилан сэргийлэх, судалгаа, сургалт, авран хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх					
1.1	Газар хөдөлтөөс урьдчилан сэргийлэх, судалгаа, сургалт, авран хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх	Газар хөдөлтөөс урьдчилан сэргийлэх авран хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа идэвхжиж, хүртээмж сайжирна	Газар хөдөлтөөс урьдчилан сэргийлэх, судалгаа, сургалт, авран хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын харилцан хамтын ажиллагаа сайжирсан байна	2009-2014	ЗТБХБ, БСШУЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, Төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллага, олон улсын мэргэжлийн байгууллага
1.2	Газар хөдөлтөөс урьдчилан сэргийлэх авран хамгаалах чиглэлээр гадаад улсын зөвлөл, ижил чиг үүрэг бүхий зөвлөл, байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, хамтын ажиллагааг тогтворжуулах, олон улсын мэргэжлийн байгууллага, нийгэмлэгт элсэх, хамтарсан сургалт, семинар зохион байгуулахад туслалцаа үзүүлэх	Гадаад орны дэмжлэг туслалцаа, хамтын ажиллагаа нэмэгдсэн байна Олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай боловсон хүчин бий болно	Газар хөдөлтөөс урьдчилан сэргийлэх авран хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэд, байгууллагуудын тооны өсөлт, олон улсын дэмжлэг, хөрөнгө оруулалтын хэмжээний өсөлт, хамтын ажиллагаа, сургалтын төлөвлөгөө, төсөл хэрэгжсэн байна	2009-2020	ЗТБХБ, БСШУЯ, СЯ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, Монголын барилгын инженерүүдийн холбоо ЛМБИХ, олон улсын мэргэжлийн байгууллага
1.3	Газар хөдөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын мэргэжлийн байгууллага, нийгэмлэгтэй мэдээлэл болон мэргэжилтэн харилцан солилцох, үндэсний мэргэжилтнийг бэлтгэх, дадлагажуулах ажлыг зохион байгуулах	Гадаад орноос үзүүлэх дэмжлэг туслалцаа, оролцоо, хамтын ажиллагаа нэмэгдсэн байна Мэргэжилтнүүдийн үр чадвар дээшилнэ	Мэргэжилтнүүдийн тооны өсөлт, сургалтын чанарт гарсан өөрчлөлт	2009-2020	БСШУЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, олон улсын мэргэжлийн байгууллага
1.4	Гамшигын хор холбогдлыг бууруулахад шинэчлэх ухаан, технологийн ололт, амжилтыг нэвтрүүлэх	Судалгаа, шинжилгээний ажлын түвшинг олон улсын жишээт хүргэнэ	Олон улсын жишээт нийцсэн шалгуур үзүүлэлттэй болсон байна	2009-2020	БСШУЯ, ОБЕГ, СЯ, МБИХ, аймаг, нийслэлийн ЗДТГ, олон улсын мэргэжлийн байгууллага

1.5	Газар хөдөлтийн гамшигт нэрвэгдсэн хүмүүст эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх сургалт зохион байгуулах	Мэргэжилтнүүдийн ур чадвар дээшилнэ	Мэргэжилтнүүдийн тоо, сургалтын чанар дээшилсэн байна	2009-2014	ЭМЯ, БСШУЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, олон улсын мэргэжлийн байгууллага
1.6	Хот байгуулалт, барилгын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрт газар чичирхийллийн нөлөөллийг тооцох, төлөвөх хичээл нэмэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, кредит цагийг нэмэгдүүлэх, баш нарыг даван сургах, мэргэшүүлэх	Газар хөдөлтийн чиглэлээр үндэсний боловсон хүчний мэдлэг чадвар дээшилнэ	Сургалтын чанар дээшилсэн байна	2009-2020	БСШУЯ, СЯ, ШУТИС-ийн Барилгын инженер-архитектурын сургууль
1.7	Монгол Улсын нутаг дэвсгэрт болсон газар хөдөлтийн бүртгэлийн мэдээллийн санг баяжуулах, олон улсын мэргэжлийн байгууллага, нийгэмлэгтэй мэдээлэл болон мэргэжилтэн харилцан солилцох, үндэсний мэргэжилтнийг бэлтгэх, дэдлагажуулах ажлыг зохион байгуулах	Олон улсын түвшинд мэдээлэл солилцох боломж нэмэгдэнэ	Олон улсын түвшинд мэдээлэл солилцох боломж бүрдэж, мэдээллийн сангийн нэр төрөл, хэмжээ өссөн байна	2009-2020	БСШУЯ, СЯ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв,
Хоёр. Газар хөдөлтийн аюулын үнэлгээ хийж, ерөнхий болон бичил мужлалын зураг зохиох, газар хөдлөлт бүртгэх станцын сүлжээг өргөтгөх					
2.1	Монгол орныг хамарсан газар хөдөлтийн ерөнхий мужлалын зураг боловсруулах ажлыг нэгдсэн аргачлал, шинэчлэх ухаан, технологийн дэвшилд тулгуурлан зохион байгуулах	Монгол орны газар хөдөлтийн ерөнхий мужлалын зураг шинэчлэгдэнэ	Монгол орныг хамарсан газар хөдөлтийн ерөнхий мужлалын зураг зохиох ажлыг шат дараалалтайгаар эхлүүлсэн байна	2009-2015	БСШУЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв, олон улсын мэргэжлийн байгууллага
2.2	Газар хөдөлтийн өндөр эрсдэл бүхий хот, суурин газар, бүсүүдийн тулгуур төв болон зарим суурин газрын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:10000-ны масштабтай газар хөдөлтийн бичил мужлалын зураг зохиох ажлыг үе шатаар хэрэгжүүлэх	Газар хөдөлтийн өндөр эрсдэл бүхий хот, суурин газрын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад бичил мужлалын зураг ашиглаж эхэлнэ	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнд нийслэл, зарим төв, суурин газрын бичил мужлалын зураг хийгдсэн байна	2009-2015	БСШУЯ, СЯ, аймаг нийслэлийн ЗДТГ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв, олон улсын мэргэжлийн байгууллага
2.3	Газар чичирхийллийг бүртгэх, мэдээлэл боловсруулах байнгын станцыг шинээр байгуулах	Газар чичирхийллийг бүртгэх, мэдээлэл боловсруулах станцын тоо нэмэгдэнэ	Газар чичирхийллийг бүртгэх, мэдээлэл боловсруулах байнгын 3 станцыг шинээр байгуулсан байна	2009-2020	БСШУЯ, СЯ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв, олон улсын мэргэжлийн байгууллага
2.4	Орон нутагт ажиллаж байгаа газар хөдлөлт бүртгэх станцын дэд бүтцийг сайжруулах боловсон хүчний чадавхийг нь дээшлүүлэх	Орон нутагт газар хөдөлтийг бүртгэх станцын үйл ажиллагааг сайжруулж олон улсын түвшинд хүргэнэ	Орон нутагт газар хөдлөлт бүртгэх станцын дэд бүтцийг сайжруулж, инженер төхөөрөмжийн ажилтнуудын ур чадвар дээшилсэн байна	2009-2020	БСШУЯ, СЯ, Аймаг нийслэлийн ЗДТГ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв,
2.5	Газар хөдөлтийн судалгаа эрхэлдэг байгууллагыг газар хөдлөлт бүртгэх нүүдлийн станц болон геофизикийн орчин үеийн иж бүрэн багаж, техник хэрэгслээр хангах	Орчин үеийн дэвшилтат техник, багаж тоног төхөөрөмж ашиглан газар хөдөлтийн нарийвчилсан аюулын үнэлгээг тогтооно	Судалгааны байгууллагуудын нүүдлийн станц болон геофизикийн орчин үеийн багаж тоног төхөөрөмжөөр хангасан байна	2009-2020	БСШУЯ, СЯ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв, олон улсын мэргэжлийн байгууллага
2.6	Хүн ам олноор суурьшсан Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хөрөнхий хурдатгалын бичлэг /акселограммыг хийх	Өндөр барилгын тооцонд ашиглах газар хөдөлтийн үеийн хөрөнхий хурдатгалын бичлэг /акселограммыг хийнэ	Газар хөдөлтийн үеийн хөрөнхий хурдатгалын бичлэг /акселограммыг хийгдсэн байна	2009-2014	БСШУЯ, СЯ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв, олон улсын мэргэжлийн байгууллага



Гурав. Хот суурин болон бүс нутгийн эрсдэлийн үнэлгээг хийх

3.1	Хангайн, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийх Газар хөдлөлтийн гамшигийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, тектоникийн судалгааны ажлыг орчин үеийн технологийн түвшинд хийх	Газар хөдлөлтийн гамшигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эхлэл тавигдана	Газар хөдлөлтийн гамшигийн эрсдэлийн үнэлгээ хот, суурин газрууд, дэд бүтцийн инженерийн шугам сүлжээнд хийгдсэн байна	2009-2014	ЗТБХБЯ, БСШУЯ, СЯ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв, Монголын Барилгын инженерүүдийн холбоо ЛМБИХ, олон улсын мэргэжлийн байгууллага
3.2	Хот, суурин газруудын газар хөдлөлтийн гамшигийн эрсдэлийн үнэлгээний ажлыг дуусгах, мэдээллийн сан байгуулах	Газар хөдлөлтийн гамшигийн эрсдэлийн бүртгэл, мэдээллийн сантай болно	Монгол Улсын хэмжээний бүртгэл, мэдээллийн сантай болсон байна Төлөвлөгөө, төсөл хэрэгжсэн байна	2015-2020	ЗТБХБЯ, БСШУЯ, СЯ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв, олон улсын мэргэжлийн байгууллага
3.3	Хангайн, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотод ашиглагдаж байгаа 1970 оноос өмнө баригдсан олон нийт, иргэний болон үйлдвэрийн барилга, дэд бүтцийн байгууламжуудад үзлэг, тооллого явуулж, паспортжуулах, газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн номлт арга хэмжээг үе шатаар эхлүүлэх	1970 оноос өмнө баригдсан барилгуудад газар хөдлөлтийг тэсвэрлэх номлт арга хэмжээ аавсан байх	Төлөвлөгөө, төсөл хэрэгжсэн байна	2015-2020	ЗТБХБЯ, БСШУЯ, СЯ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв, олон улсын мэргэжлийн байгууллага
3.4	Барилга байгууламжийг загварчилж бодит байдалд турших, дүн шинжилгээ хийх, барилгын бүтээц болон түүний элементийг газар хөдлөлтөд турших, багаж, тоног төхөөрөмж бүхий лабораторитой болгох, ашиглагдаж байгаа туршилтын багаж, тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх	Туршилт, шинжилгээний лабораторитой болно	Төлөвлөгөө, төсөл хэрэгжсэн байна	2009-2014	ЗТБХБЯ, БСШУЯ, СЯ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, олон улсын мэргэжлийн байгууллага
3.5	Эрсдэс байлал, уул урхайн томоохон цогцолборуудыг дагаж байгуулагдах суурин газрын газар хөдлөлтийн эрсдэлийг тогтоосон баримт бичиг боловсруулах	Шинээр хот суурин газруудыг төлөвлөхөд газар хөдлөлтийн эрсдэлээс сэргийлэх тогтолцооны баримт бичигтэй болсон байна	Төлөвлөгөө, төсөл хэрэгжсэн байна	2009-2020	ЗТБХБЯ, БСШУЯ, СЯ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв, олон улсын мэргэжлийн байгууллага
3.6	Эрүүл мэндийн болон боловсролын байгууллагын барилгын даац, бат бэх, газар хөдлөлтөд тэсвэртэй байдлын үнэлгээ хийх	Барилгын аюулгүй байдал хангагдана	Төлөвлөгөө, төсөл хэрэгжсэн байна	2010-2014	БСШУЯ, ЗТБХБЯ, СЯ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, олон улсын мэргэжлийн байгууллага
3.7	Хангайн, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотын 1:1000-аас доошгүй масштабын газрын дижитал зургийн санг байгуулах	Гамшигийн аюулыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэхэд барилга байгууламжийн байршлын дижитал зургийн сантай болно	Хангайн, төвийн болон баруун бүсийн тулгуур төвүүд болон Улаанбаатар хотын 1:1000-аас доошгүй масштабын газрын дижитал зургийн сантай болсон байна	2009-2014	БСШУЯ, СЯ, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв, олон улсын мэргэжлийн байгууллага
Дөрөв. Гамшигаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшшуулшгүй сэргээн босгох ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах					
4.1	Газар хөдлөлтийн гамшигийн үед аюуллах, аврах, хор уршгийг арилгах, хойшшуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөөг томоохон хот суурин газар бүрээр боловсруулж, гамшигаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх	Газар хөдлөлтийн гамшигийн үед мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллах чиглэл тодорхой болсон байна	Газар хөдлөлтийн гамшигийн үед аюуллах, хор уршгийг арилгах, хойшшуулшгүй сэргээн босгох төлөвлөгөө боловсруулж, томоохон хот суурин газарт гамшигаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдал дээшилсэн байна	2009-2014	ОБЕГ, ЗТБХБЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ

4.2	Гамшгаас хамгаалах алба, аймаг, орон нутагт явуулдаг газар хөдөлтийн гамшгаас урьчилан сэргийлэх дадлага, сургалтад холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллаж болзошгүй гамшгийн үед ажиллах хамтын ажиллагааг сайжруулж, газар хөдөлтийн гамшигтай тэмцэх чадавхийг дээшлүүлэх	Гамшгийн үед хамтран ажиллах дадлага туршлагатай болно	Гамшгаас хамгаалах сургууль дадлагад мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллаж, болзошгүй гамшгийн үед хамтран ажиллах, гамшигтай тэмцэх чадавхийг дээшлүүлсэн байна	2009-2014	ОБЕГ, ЗТБХБЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ
4.3	Газар хөдөлтийн гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох ажилд шаардлагатай багаж хэрэгслийг буцалтгүй тусламж, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хамруулан шинэчлэх арга хэмжээ авах	Гамшгийн үед авран хамгаалах иж бүрэн багаж, тоног төхөөрөмжтэй болно	Буцалтгүй тусламж, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд газар хөдөлтийн гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох ажилд шаардлагатай багаж хэрэгслийн хангалтыг сайжруулан, гамшигтай тэмцэх бэлэн байдал дээшлсэн байна	2015-2020	ОБЕГ, ЗТБХБЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ
4.4	Олон нийтэд газар хөдөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх болон газар хөдөлтийн гамшгийн үеийн авран хамгаалах талаар сургалт зохион байгуулах, сурталчлах, гамшгийн хор холбогдлыг тайлбарлан таниулах	Газар хөдөлтийн үед авран хамгаалах хамтран ажиллах талаар салбарын мэргэжлийн байгууллагуудаас сургалт семинар зохион байгуулснаар гамшгийн үед олон нийтийн оролцоотойгоор авран хамгаалах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах үндэс тавигдана	Сургалт, семинар зохион байгуулж байгаа телевиз, радио, сонин, сэтгүүлийн байгууллагуудын тоо нэмэгдсэн байна	2009-2014	БСШУЯ, ОБЕГ, ЗТБХБЯ
4.5	Олон улсын арга хэмжээнд идэвхтэй оролцон гамшгийн хор холбогдлыг бууруулахад шинэчлэх ухаан, технологийн ололт, амжилтыг нэвтрүүлэх	Газар хөдөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх асуудлыг олон улсын хамгийн сүүлийн үеийн шинэчлэх ухаан технологийн дэвшилтэд тулгуурлан хэрэгжүүлнэ	Шинэчлэх ухаан, технологийн инноваци эрчимтэй нэвтэрсэнээр газар хөдөлтийн гамшгийн эрсдэлийг багасгах таатай орчин бүрдсэн байна	2009-2020	БСШУЯ, ОБЕГ, ЗТБХБЯ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 7.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Булган-Үеэн-Ховдын чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэгч "Читай" ХХК-ийн 260, Ханбүргэдэй-Солонготын даваа чиглэлийн 100 км хатуу хучилттай замын гүйцэтгэгч "Алтанзам гүүр" ХХК-ийн 190, Хөшөөтийн нүүрсний уурхай-

Барлаг-Ярантын боомт хүртэлх 340 км авто зам, гүүр барих "Мо Эн Ко" ХХК-ийн 1900, "100 мянган айлын орон сууц" хөтөлбөрийн хүрээнд барилгын ажил гүйцэтгэх "МКХ" ХХК-ийн 450, "Азунхуй" ХХК-ийн 200, "Зунгуо жизнь жү Монгол" ХХК-ийн 300, "Иншидин" ХХК-ийн 80, "Зуншин" ХХК-ийн 250, "Монтед" ХХК-ийн 250, "Задран" ХХК-ийн 500 инженер техникийн болон мэргэжлийн ажилтанд 2009 онд

Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид даалгасугай.

2. "Аззунхуай" ХХК-ийн 100, "Иншифин" ХХК-ийн 40, "Задран" ХХК-ийн 250 инженер техникийн болон мэргэжлийн ажилтныг энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хугацаанд ажлын байрны төлбөрөөс чөлөөлсүгэй.

3. Энэхүү тогтоолын дагуу авч ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2009 онд багтаан буцаан гаргах ажлыг зохион байгуулж дүнг

Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД** **Т.ГАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 161

Улаанбаатар
хот

**Үл хөдлөх хөрөнгө худалдах,
балансаас балансад шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Нээлттэй дуудлага худалдаагаар худалдах үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг 1 дүгээр хавсралт, балансаас балансад шилжүүлэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус

тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **Б.ДОЛГОР**

Засгийн газрын 2009 оны 161 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үл хөдлөх хөрөнгийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Балансын үнэ /мян.төг/	Эзэмшигч хуулийн этгээд
1	Төмөргүйжүүлэх станцын барилга	Улаанбаатар Багануур дүүрэг	1981	69,525.7	"Багануурын дулааны станц" ТӨХК
2	Агуулахын барилга	Улаанбаатар Багануур дүүрэг	1990	1,405.5	"Багануурын дулааны станц" ТӨХК
3	Автомашин гараашийн барилга	Улаанбаатар Багануур дүүрэг	1980	4,280.6	"Багануурын дулааны станц" ТӨХК
4	Орон сууцны барилга	Говьсүмбэр Чойр	1992	658.4	"Багануур-3үүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК
5	Радио төвийн барилга	Өмнөговь Даланзадгад сум	1957	12,291.4	Өмнөговь аймгийн "Гурвансайхан" олон улсын нисэх буудал
6	Агуулахын барилга	Өмнөговь Даланзадгад сум	1957	590.4	Өмнөговь аймгийн "Гурвансайхан" олон улсын нисэх буудал
7	Ойрын чиглүүлэх станцын барилга	Өмнөговь Даланзадгад сум	1980	654.1	Өмнөговь аймгийн "Гурвансайхан" олон улсын нисэх буудал
8	Конторын барилга	Дорнод Чойбалсан сум	1991	15,000.0	Дорнод аймгийн хуучин нисэх буудал
9	Радио төвийн барилга	Улаанбаатар Хан-Уул дүүрэг	1981	25,079.4	"Чингис хаан" Олон улсын нисэх буудал
10	Орон сууцны барилга	Дархан-Уул Дархан сум	2004	211,600.0	"Дарханы дулааны сүлжээ" ТӨХК

11	Зуслангийн 2 айлын байр	Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг	1970	169.9	Талнуулын ерөнхий газар
12	Зуслангийн байр	Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг	1970	84.9	Талнуулын ерөнхий газар
13	Манаачийн байр	Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг	1970	45.0	Талнуулын ерөнхий газар
14	Конторын барилга	Увс Улаангом сум	1970	658.7	"Увс АЗЗА" ТӨХХ
15	Автомашин гараашийн барилга	Увс Улаангом сум	1997	2,952.0	"Увс АЗЗА" ТӨХХ
16	Агуулахын барилга	Увс Улаангом сум	1992	47.1	"Увс АЗЗА" ТӨХХ
17	Автомашин гараашийн барилга	Сүхбаатар Баруун-Урт сум	1965	33.6	Сүхбаатар аймгийн Прокурорын газар
18	Конторын барилга	Дорноговь Замын-Үүд сум	1995	27,715.3	Тээврийн үйлчилгээний төвийн Замын-Үүд дэх салбар
19	Конторын барилга	Сэлэнгэ Сайхан сум	1980	9,341.1	Хөтөл дэх сум дундын 3 дугаар шүүх
20	Номын сангийн барилга	Улаанбаатар Баянзүрх дүүрэг	1964	57,900.4	Дотоодын цэргийн 805 дугаар анги
21	Агуулахын барилга №15	Улаанбаатар Баянзүрх дүүрэг	1964	45,000.0	Дотоодын цэргийн 805 дугаар анги
22	Агуулахын барилга №16	Улаанбаатар Баянзүрх дүүрэг	1964	54,000.0	Дотоодын цэргийн 805 дугаар анги
23	Хүнсний зоорь №8а	Улаанбаатар Баянзүрх дүүрэг	1964	1,600.0	Дотоодын цэргийн 805 дугаар анги
24	Ажилчны клубийн барилга	Улаанбаатар Хан-Уул дүүрэг	1955	17,654.9	"Биокомбинат" ТӨҮГ
25	Конторын барилга	Дархан-Уул Шарын гол сум	1985	3,200.0	Сум дундын шүүх
26	ОСИБО объект	Дархан-Уул Дархан сум	1976	851,200.0	Дарханы төмөрлөгийн үйлдвэр
27	Конторын барилга	Увс аймгийн Улаангом сум	1956	5,657.3	Дэлхийн өв Увс нуурын ай савын Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа
28	Төмсний зоорь (1000 тоннын)	Дархан-Уул Хонгор сум	1985	2,017.2	Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн
29	Төмсний зоорь (150 тоннын)	Дархан-Уул Хонгор сум	1985	310.2	Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн
30	Манжийн зоорь (10 тоннын)	Дархан-Уул Хонгор сум	1985	5.7	Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн
Нийт дүн				1,420,678.8	

Засгийн газрын 2009 оны 161 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үл хөдлөх хөрөнгийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Балансын үнэ /млн.төг/	Эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэн авах байгууллага
1	Зорчигчдын байр	Архангай Цэцэрлэг сум	1996	3,792.7	Архангай аймгийн нисэх буудал	Авто тээврийн газар
2	Конторын барилга	Архангай Цэцэрлэг сум	1972	5,647.2	Архангай аймгийн нисэх буудал	Авто тээврийн газар
3	Гуанзны барилга	Архангай Цэцэрлэг сум	1984	5,168.2	Архангай аймгийн нисэх буудал	Авто тээврийн газар
4	Ачаа тээврийн байр	Архангай Цэцэрлэг сум	1992	1,373.1	Архангай аймгийн нисэх буудал	Авто тээврийн газар
5	Аварийн моторын байр	Архангай Цэцэрлэг сум	1998	3,342.6	Архангай аймгийн нисэх буудал	Авто тээврийн газар
6	Сахиулын байр	Архангай Цэцэрлэг сум	2000	9,603.7	Архангай аймгийн нисэх буудал	Авто тээврийн газар
7	Зорчигч, үйлчилгээний барилга	Өмнөговь Даланзадгад сум	1972	5,400.0	Өмнөговь аймгийн хуучин нисэх буудал	Авто тээврийн газар
8	Цайны газрын барилга	Улаанбаатар Баянгол дүүрэг	1986	8,557.6	"Улаанбаатар АЗЗА" ТӨХХ	Авто замын газар
9	Конторын барилга	Баянхонгор Баянхонгор сум	1961	3,624.0	Баянхонгор аймгийн Прокурорын газар	Талнуулын ерөнхий газар
10	Холбооны салбарын барилга	Дархан-Уул Дархан сум	1994	302,204.4	"Мэдээлэл, холбооны сүлжээ" ХХК	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
Нийт дүн				348,713.5		



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 16 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэргийн талаар заасан Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон **Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:**

1. Эрүүгийн хуулийн /цаашид хуулийн гэж/ 108 дугаар зүйлийн зарим заалтыг дор дурдсанаар тайлбарласугай.

1.1 "Хүн хулгайлсан" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 5.9-д заасны дагуу ойлгоно.

1.2 "Хүнд хор уршиг" гэдэгт хүний амь хохирсон, ураг зулбасан буюу хүүхэд дутуу төрүүлсэн, бие махбодид нь хүнд гэмтэл учруулсан, сэтгэцийн болон бусад хүнд өвчнөөр өвчилсөн, хөгжлийн бэрхшээлтэй болсон, хүн хулгайлагдсантай холбоотойгоор гэр бүлийн гишүүдийнх нь аль нэг хүндээр өвчилсөн, сэтгэцийн өвчинтэй болсон, эд хөрөнгөнд нь их буюу онц их хэмжээний хохирол учирсан зэргийг хамааруулан үзнэ.

2. Хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1-д заасан "хүнийг хууль бусаар хорих" гэж хохирогчийг хуурч мэхлэн, эсхүл хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх зэргээр түүний хүсэл зоригоос гадуур чөлөөтэй зорчих эрхийг нь тодорхой хугацаанд хязгаарлаж байгаа үйлдлийг хэлнэ.

Харин энэ гэмт хэргийг үйлдсэний дараа иргэн, хуулийн этгээдээс мөнгө, эд хөрөнгө гаргуулах буюу өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх, эсхүл үйлдэл гүйцэтгэхээс татгалзуулах болзол тавьсан бол уг үйлдлийг хуулийн 112 дугаар зүйлээр зүйлчилнэ.

3. Хуулийн 112 дугаар зүйлийн зарим заалтыг дор дурдсанаар тайлбарласугай.

3.1 "Барьцаалах" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 5.9-д болон Хүн барьцаанд авахын

эсрэг 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн конвенцийн 1 дүгээр зүйлд заасны дагуу буюу "гурав дахь этгээдээр, тухайлбал улс, засгийн газар хоорондын олон улсын байгууллага, хувь хүн, хуулийн этгээд, эсхүл бүлэг этгээдээр аливаа үйлдэл гүйцэтгүүлэх буюу гүйцэтгэхээс татгалзуулах зорилгоор өөр нэг хүн /барьцааны хүн/ -ийг суллах шууд буюу шууд бус болзол болгон тавьж, түүнийг олзлох буюу саатуулах, амийг нь хөнөөх, бие махбодид нь гэмтэл учруулах, эсхүл үргэлжлүүлэн саатуулахаар заналхийлж буй үйлдэл" гэж ойлгоно.

3.2 "Болзол" гэдэгт гэмт этгээдээс иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад гаргаж буй хууль бус аливаа шаардлага хамаарна.

3.3 "Барьцаанд байгаа хүний амь биед заналхийлж" гэж бие махбодийн болон сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэн айлган сүрдүүлснийг хэлнэ.

4. Хуулийн 108 дугаар зүйлийн 108.2.5, 109 дүгээр зүйлийн 109.2.2-т тус тус заасан "амь биед нь аюултай хүч хэрэглэж" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 13 дугаар тогтоолын 5-д зааснаар ойлгоно.

5. Хуулийн 108 дугаар зүйлийн 108.2.6, 109 дүгээр зүйлийн 109.2.3, 112 дугаар зүйлийн 112.2.6-д тус тус заасан "зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 3 дугаар тогтоолын 1, 2-т заасны дагуу ойлгож хэрэглэнэ.

6. Хуулийн 110, 111 дүгээр зүйлүүдийн зарим заалтыг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 40, мөн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоолоор тус тус тайлбарласан болохыг дурдсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Б.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.

Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын

Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12

Төрийн ордон-128 тоот

и-мэйл: turin_medeelel@parliament.mn



262420, 329612

Индекс 14003



329487

Хэвлэлийн хуудас 1.5